

## **“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2019 оны 5 дугаар сарын 3-ны өдөр

№ 19/27

Улаанбаатар хот

### **Компанийн 2019 оны эх үүсвэрийн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.4, 80.5 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК-ийн дүрмийн 9.6.4, 9.6.5 дахь заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2019 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн хурлын 19/12 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Компанийн 2019 оны эх үүсвэрийн төлөвлөгөө”-ний Хавсралтад заасан хөрөнгө итгэмжлэн удирдах, өрийн бичиг гаргах, зээлийн эх үүсвэр татах жишиг нөхцөлүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулж, энэхүү тогтоолын 1 дүгээр Хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Компанийн 2019 оны эх үүсвэрийн төлөвлөгөө, энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсан жишиг нөхцөлийн хүрээнд хөрөнгө итгэмжлэн удирдах, өрийн бичиг гаргах, зээлийн эх үүсвэр татах, түүнтэй холбоотой гэрээ, хэлцэл байгуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д зөвшөөрсүгэй.
3. Компанийн 2019 оны эх үүсвэрийн төлөвлөгөө, энэхүү тогтоолын Хавсралтад заасан хэмжээ, жишиг нөхцөлөөс давсан болон хоёрдогч эх үүсвэрийн санал, Компанийн тухай хуулийн дагуу тогтоосон их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулсны үндсэн дээр байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д даалгасугай.
4. Эх үүсвэрийн төлөвлөгөөний гүйцэтгэл, татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн талаарх мэдээллийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол тайлагнахыг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д үүрэг болгосугай.

**ТУЗ-ИЙН ДАРГА:**

..... /О.БОЛДБААТАР/



## **“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2019 оны 5 дугаар сарын 3-ны өдөр

№ *19/28*






Улаанбаатар хот

### **Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.4, 80.5, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.20, 9.10, 9.11 дэх заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Гадаад валютын ханшийн эрсдлийг удирдах зорилгоор Анд Системс ХХК-тай 4 сая ам.доллар хүртэлх хэмжээний гадаад валютын СВОП хэлцлийг энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан нөхцөлийн дагуу хийх, СВОП хэлцэлийг байгуулж, холбогдох гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д олгосугай.
2. Анд Системс ХХК-тай байгуулсан СВОП хэлцлийн нөхцөлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.

### **ТУЗ-ИЙН ГИШҮҮД:**

|                                                                                     |                      |                                                                                      |                      |
|-------------------------------------------------------------------------------------|----------------------|--------------------------------------------------------------------------------------|----------------------|
|  | ...../С.ЭНХ-АМГАЛАН/ |  | ...../Ж.ЖАРГАЛСҮРЭН/ |
|  | ...../С.БОРГИЛ/      |  | ...../Н.ЦЭВЭГМИД/    |
|  | ...../Ч.НОМИН/       |                                                                                      |                      |



# **“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2019 оны 5 дугаар сарын 3-ны өдөр

№ 19/29

Улаанбаатар хот

## **Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, Зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.2 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.4, 80.5, 89 дүгээр зүйлийн 89.1.1 дэх заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.4, 9.6.20, 9.10, 9.11 дэх заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн эчнээ санал хураалтын дүнг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан Анд Системс ХХК-аас дараах нөхцөлийн дагуу гэрээ байгуулж зээл авах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д олгосугай.

|                      |                                                                                    |
|----------------------|------------------------------------------------------------------------------------|
| Санхүүжилтын төрөл   | Зээл                                                                               |
| Зээлийн хугацаа      | 36 сар хүртэл хугацаатай                                                           |
| Зээлийн хүү          | Анд Системс ХХК-ийн татсан эх үүсвэр өртөг дээр холбогдох татвар нэмж тооцсон хувь |
| Зээлийн хэмжээ       | 10,000,000,000 (арван тэрбум) төгрөг хүртэл                                        |
| Зээлийн эргэн төлөлт | Анд Системс-ийн санхүүжилтын эх үүсвэрийн эргэн төлөх нөхцөлийн дагуу              |
| Барьцаа              | Барьцаагүй                                                                         |

2. Зээлийн нөхцөлийг энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд хэлэлцэн тохирох, Зээлийн гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д олгосугай.
3. Анд Системс ХХК-тай байгуулсан Зээлийн гэрээ, санхүүжилтийн нөхцөлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.
4. Татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж буй ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Гантулга)-д үүрэг болгосугай.

### **ТУЗ-ИЙН ГИШҮҮД:**

...../С.ЭНХ-АМГАЛАН/ ...../Ж.ЖАРГАЛСҮРЭН/  
...../С.БОРГИЛ/ ...../Н.ЦЭВЭГМИД/  
...../Ч.НОМИН/

